



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/17

Даланзадгад сум

Комиссын бүрэлдэхүүн шинэчлэн
томилох тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.1 дүгээр зүйл, Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7, 7.8, 7.9 дэх заалтууд, Эрүүл мэндийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/40 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эм эмнэлгийн хэрэгсэл худалдах тусгай зөвшөөрөл олгох комиссыг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн томилсугай.

Комиссын дарга:

Эрүүл мэндийн газрын дарга

Орлогч дарга:

Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтсийн дарга

Гишүүд:

Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын
Эм биобэлдмэлийн хяналтын улсын ахлах байцаагч

Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга

Хяналт шалгалтын хэлтсийн дарга

Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга

Саран ээж төрийн бус байгууллагын удирдлага

Нарийн бичиг:

Эмийн бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн

2.Тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, цуцлах үйл ажиллагааг хууль журмын хүрээнд зохион байгуулж ажиллахыг комисст үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс (Б.Цагаанцэнд)-д даалгасугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/86 дугаар тушаал хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ц.ЖАВЗАНДУЛАМ

462501117